# НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 20 өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

Дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Дүүргийн Засаг даргаас өргөн мэдүүлсний дагуу Хан-Уул дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Б.Цэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.БАТ-ОРГИЛ

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны
өдрийн 12 дугаар тогтоолын
хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 2025 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

| Д/Д | ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА | ХУГАЦАА | ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ ҮНДЭСЛЭЛ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| *Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил* | | | | |
| 1. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 69 дүгээр тогтоолоор Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоосонтойгоор холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | НЗДТГ, НБОГ, НГЗБА, НХБХСГ, УСУГ | I-IV улиралд | Монгол Улсын Усны тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах; |
| 2. | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Улаанбаатар хотын эдэлбэр газар, түүнтэй холбоотой дүрэм, журмын төсөлд санал өгөх | НГЗБА, НХБХСГ | I-IV улиралд | Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль; |
| 3. | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах. | НЗДТГ, НГЗБА | I-IV улиралд | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоол; |
| *Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил* | | | | |
| 4. | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн, нийтийн эрх ашиг болон газар эзэмших, ашиглах эрх нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээдийн эдэлбэр газрыг газраар дүйцүүлэн олгохоор тогтоосон газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах талаар хуулийн хүрээнд хамтарч ажиллах | НГЗБА, НЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10, 29.12; |
| 5. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, НХБХСГ, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт; |
| 6. | Газар эзэмших эрх нь дуусгавар болсон, зөвшөөрөлгүй ашигласан газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барих, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор | НЗДТГ, ЗАА, НГЗБА, ДЗДТГ | I-IV улиралд | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дах заалт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4.1 дэх заалт Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах санал өгөх | | | |
| 7. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг тогтооход санал өгөх | НЗДТГ, ЗАА, НГЗБА, НБОГ, ДЗДТГ | I-IV улирал | Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай 58 дугаар зарлигийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар зөвлөмж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамж; |
| ***Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил*** | | | | |
| ***Хот байгуулалтын чиглэлээр:*** | | | | |
| 8. | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэр дэх улсын зэрэглэлтэй 2, орон нутгийн зэрэглэлтэй 14, дагуул 3 хотын эдэлбэр газрын хэмжээ, хил заагийн байршлыг тогтооход санал өгөх | ХТСИ, НХБХСГ, НГЗБА | I-IV улирал | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2008 оны 18 дугаар тогтоол; |
| 9. | Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хашаа, хайстай байх нэгж талбаруудад "UCS 1410B Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага" хотын стандартыг хангуулах ажлыг хамтран зохион байгуулах, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | НГЗБА, НХБХСГ, НХШГ | I-IV улирал | Газрын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 5.3 дах заалт Газрын төлбөрийн тухай хууль, |
| 10. | Орон сууцны хороолол дундах автомашины гаражнуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх, сургууль, цэцэрлэгийн байгууллагад боломжит байршлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | НГЗБА, НХБХСГ, НХШГ | I-IV улирал | Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт; |
| 11. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | НГЗБА, НХБХСГ, ХСОАБХЗГ | I-IV улирал | "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, ЗТБХБСайдын 2010 оны 418 дугаар тушаал; |
| 12. | Авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | НХБХСГ, НГЗБА, ДЗДТГ | I-IV улирал | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол; |
| 13. | Дүүргийн нутаг дэвсгэрт явган зам болон дугуйн зам, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, ногоон байгууламжийн байршлын судалгааг гаргаж, холбогдох ажлыг зохион байгуулах | ЗАА, НХБХСГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улирал | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14. | Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг судлан, дүн шинжилгээ хийж, шинээр газар эзэмших ашиглах, өмчлөх эрх олгохгүй байх, Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайг байгуулахад "Ногоон байгууламж", "Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө" бүлгийн батлагдсан хотын стандартыг хангуулах ажлыг хамтран зохион байгуулах | УБЗАА, НХБХСГ, НГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 61.1 "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно" дахь заалт; |
| ***Газар зохион байгуулалтын чиглэлээр:*** | | | | |
| 15. | Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ шинэчлэх үйл ажиллагаанд хамрагдаагүй үндсэн газар эдлэх эрхийн үнэмлэхтэй, тухайн газраа олон жил амьдарсан боловч газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ авч байгаагүй иргэдийн газар эзэмших эрхийг хууль тогтоомжид заасан хугацаагаар холбогдох журмын дагуу шинэчлэн олгох | НГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна" дах хэсэг |
| 16. | Дүүргийн нутаг дэвсгэрт дэх түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий иргэн, хуулийн этгээдүүдийн газар ашиглалтад хяналт тавих | НЗДТГ, НБОГ, НГЗБА | I-IV улиралд | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль; |
| 17. | Улс, нийслэл, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэх авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээ, нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж (сургууль, цэцэрлэг, эмнэлэг г.м) барих газрын байршлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА, НХБХСГ | I-IV улиралд | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.3 дах заалт; |
| 18. | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах, чанарын төлөвлөгөөт хянан баталгааг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулах | НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.7 "…. анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" дах заалт; |
| 19. | Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах, зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах. | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дахь заалт; |
| 20. | Газрын тухай хуульд заасан үндэслэл буюу *1.улс, орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гарсан байршилтай давхацсан, 2.Улс, нийслэлийн төсөв, гадаад зээл, тусламжаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх байршилтай давхацсан, 3. хориглолт, хамгаалалт, хязгаарлалтын бүс, зурвас газартай давхацсан, 4. геодезийн сүлжээ, өндөр тусгаарлагчийн тогтолцоо өөрчлөгдсөн, 5.газар зохион байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэх, 6.нийгмийн зайлшгүй* | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | *хэрэгцээг үндэслэн, 7.хүн ам, барилгажилтын нягтрал ихтэй бусад байрлах* газрыг нийтийн эдэлбэр газарт авах, нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн шийдвэр зэргийг үндэслэн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар ашиглалтын бүсчлэлд нийцүүлэн эзэмшил газрын хэмжээ, байршлыг өөрчлөх үйл ажиллагааг зохион байгуулах | | | |
| ***Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил*** | | | | |
| 21. | Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль" |
| 22. | Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол |
| 23. | Бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн, өмнөх онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдсан, газрын эрхийн аливаа зөрчилгүй талаарх гэрээ дүгнэсэн акт, иргэний хүсэлтийг үндэслэн эзэмшиж буй газрыг өмчлүүлэх | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийн 9.6 дэх заалт; "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль" |
| ***Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил*** | | | | |
| 24. | Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийг судлан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний талбайг хэсэгчлэн буюу бүхлээр нь хүчингүй болгох зэрэг холбогдох арга хэмжээг авах | НЗДТГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 61.1-д "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно" дэх заалт; |
| 25. | Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, шар усны үерт өртөх болзошгүй нэгж талбарыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх | НЗДТГ, НОБГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Барилга, хот байгуулалтын сайд /хуучнаар/-ын 2023 оны 2023/02 дугаартай албан даалгавар |
| 26. | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах, тайланг НГЗБА-нд хүргүүлэх, доройтолтой гэж үнэлэгдсэн газарт нөхөн сэргээх хамгаалах ажлыг зохион байгуулах | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 23.2.10 "газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих," 23.2.21 "газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/-ний сүлжээ ажиллуулах;" |
| 27. | Газрын кадастрын мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсгийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын байршлын кадастрын зургийг шинээр бүртгэх, эргэлтийн цэг өөрчлөх, устгах, сэргээхтэй холбоотой асуудлыг тухай бүр хэлэлцүүлэх | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хууль болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалыг хэрэгжүүлэх |
| 28. | Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах | НГЗБА, НХБХСГ, | I-IV | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эрхийг хангах газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах | ДГЗБА | улиралд | үндсэн чиглэлийн 9.4.2 дахь заалт; |
| 29. | Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, түргэн үйлчилгээний цэгийн зөвшөөрөл өгсөн эрх бүхий байгууллагад албадан чөлөөлүүлэх санал хүргүүлэх, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА | I-IV улиралд | Газрын тухай хуулийн 56.5 "Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна" дахь заалт; УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 34 дүгээр тогтоол |
| 30. | Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний хүрээнд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалангийн талбайн зориулалтаар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газарт судалгаа хийж зөрчилтэй нэгж талбаруудын газрын эрхийг хүчингүй болгох, санал өгөх | ХХААХҮЯ НЗДТГ, НХХААГ, НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол |
| 31. | Дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлүүлэхээр дүүргийн газар зохион байгуулалтын албанд ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, газар эзэмших, ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг НГЗБА-нд хянуулах | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Нийслэлийн Засаг даргын 2017 оны А252 дугаар захирамж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын 2022 оны А/53 дугаар тушаал |
| ***Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил*** | | | | |
| 32. | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах. | НЗДТГ , НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| 33. | Дүүргийн хэмжээнд газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж ДИТХ-аар хэлэлцүүлэх | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; |
| ***Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил*** | | | | |
| 34. | Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах | НГЗБА, ДГЗБА | I-IV улиралд | |
| 35. | Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дүгээр тогтоол шинэчлэгдсэн тохиолдолд иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд ногдуулсан газрын төлбөрийг шинэчлэх, гэрээг дүгнэх, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах | НЗДТГ, НГЗБА | I-IV улиралд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд |

## ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | ДҮҮРЭГ | ХОРОО | ГАЗРЫН БАЙРШИЛ | ИРГЭДИЙН ТОО | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ЗОРИУЛАЛТ | ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА | ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *2.1 Эзэмшиж буй газрыг өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ* | | | | | | | | |
| 1 | Хан-Уул | 10 | Морин, АТБ, Нисэх гудамж | 3 | 0.18 | Гэр бүлийн хэрэгцээ | I-IV улиралд | НГЗБА, ДГЗБА |
| 2 | | 12 | Хабитат, Хабитат хотхон, Цагаан эрэг, Дарцагт, Хайрхан, Дэвшил, Сонгино, Өлийн амны, Морин-Уул, Малчин гудамж | 18 | 1.26 | | | |
| 3 | | 13 | 2, 2б хэсэг, 3, 4, 4б хэсэг, 5, 5б хэсэг, 7 дугаар хэсэг, Шинэ суурьшил, Бэхэг, Сэнс толгой, Дэвшил, Уушийн ар, Таван толгой, Туул, Карьер гудамж | 20 | 1.4 | | | |
| 4 | | 14 | Гавьж, Гавьжийн шанд, Өлзийт, Өлзийтийн дэнж, Барилга, Бурхант, Адис, Ногоочид, Доод Өлзийт, Уяачид, Шинэ тосгон гудамж | 72 | 5.01 | | | |
| **Нийт** | | | | **113** | **7.85** | | | |

**2.2 Газар дээрээ олон жил амьдарсан иргэдийн газрын эрхийг баталгаажуулах газрын байршил, хэмжээг тогтоох**

| Д/Д | ДҮҮРЭГ | ХОРОО | ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ | ЗОРИУЛАЛТ | ИРГЭДИЙН ТОО | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хан-Уул | 5 | Яармаг | Гэр бүлийн хэрэгцээ | 1 | 0.0317 | I-IV улиралд | НГЗБА, ДГЗБА |
| 2. | | 6 | Нүхт, НҮН, ТТБ | | 5 | 0.1079 | | |
| 3. | | 8 | Сонсголон, Дэнж, Дугуй цагаан, Баруун ширээт, Жаргалант | | 87 | 5.34 | | |
| 4. | | 9 | Бурхант, Буянт-Ухаа | | 12 | 0.4 | | |
| 5. | | 10 | Морин, Нисэх, АТБ, Туулын задгай | | 37 | 2.01 | | |
| 6. | | 12 | Хабитат, Хайрхан, Малчин, Баяжихын хонхор, Цагаан эрэг, Морин уул | | 66 | 4.23 | | |
| 7. | | 13 | Уушийн ар, Сэнс толгой, Дэвшил, Бехег, Өлзийтийн зам, Туул, Шинэ суурьшил, Карьер | | 179 | 11.7 | | |
| 8. | | 14 | Өлзийт, Өлзийт дэнж, Бурхант, Барилга, Адис, Доод өлзийт | | 175 | 11.1 | | |
| | | | Гавьж, Гавьжийн шанд | | 259 | 17.7 | | |
| | | | Уячид, Шинэ тосгон, Ногоочид | | 291 | 18.8 | | |
| | | | Өвөр хөндлөн | | 159 | 11.09 | | |
| | | | Ар хөндлөн, Түргэний ам, Баруун хөх уул, Хар хошуу, Буга | | 350 | 23.77 | | |
| 9. | | 16 | Буянт-Ухаа, Тайнь | | 5 | 0.44 | | |
| 10. | | 17 | Оргил | | 1 | 0.063 | | |
| 11. | | 21 | Амгалан хотхон, Хараат уул, Уудам, Морин зам,Өлзийт зам | | 39 | 2.7 | | |
| 12. | Хан-Уул | 8 | Жаргалант | Төмс хүнсний ногоо | 1 | 0.19 | | |
| 13. | | 13 | Хорооны нутаг дэвсгэрт | | 35 | 31.63 | | |
| 14. | | 14 | Гавьж, Ногоочид, Уячид, Өвөр хөндлөн | | 47 | 44.72 | | |
| **Нийт** | | | | | **1749** | **186.38** | | |

| 2.3 Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Д/Д | ХОРОО | ГАЗРЫН БАЙРШИЛ | ЗОРИУЛАЛТ | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ТӨЛӨВЛӨЛТИЙН НЭГЖ ТАЛБАР | ХУГАЦАА | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
| 1. | 3 дугаар хороо | ТЭЦ-3 орчимд | Аж ахуйн хашаа | 0.3 | | I-IV улиралд | Эко Хан-Уул тээвэр ОНӨААТҮГ |
| 2. | 8 дугаар хороо | Яармаг орчимд | Гал түймэр унтраах, аврах анги | 1.5 | 4308211 | I-IV улиралд | ОБЕГ, НЗДТГ |
| 3. | 12 дугаар хороо | Морингийн даваа орчимд | Технологи дамжуулах төв | 0.4 | 4308220 | I-IV улиралд | ХББОСЯ |
| 4. | 12 дугаар хороо | Энхсаран сувиллын урд талд | Байгаль хамгаалагчийн байр | 0.037 | | I-IV улиралд | НБОГ |
| 5. | 14 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Худаг | 0.01 | 4308216 | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 6. | 14 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Мод үржүүлгийн газар | 3.0 | 4308219 | I-IV улиралд | ЦЕГ, ЭЦА |
| 7. | 14 дүгээр хороо | Өлзийт орчим | Өрхийн эрүүл мэндийн төв | 0.09 | 4308222 | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 8. | 14 дүгээр хороо | Ар хөндлөн орчим | Худаг | 0.01 | 4308215 | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 9. | 21 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Сургууль | 0.35 | 4308212 | I-IV улиралд | ХББОСЯ |
| 10. | 21 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Цэцэрлэг | 0.3 | 4308213 | I-IV улиралд | ХББОСЯ |
| 2.3.а Газрын эрхийг хэсэгчлэн болон бүхлээр нь хүчингүй болгох, дуусгавар болсон байршилд төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлэх | | | | | | | |
| 11. | 3 дугаар хороо | Яармагийн гүүр орчимд | Сургалтын талбай | 10 | | I-IV улиралд | МУДЦШ |
| 12. | 14 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Амины орон сууц | 7.0 | 4308221 | I-IV улиралд | МИАТ ТӨХК |
| 13. | 21 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | Архивын байр | 0.5 | 4308223 | I-IV улиралд | НАГ |
| | Нийт | | | 23.497 | | | |

| 2.4 Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Д/Д | ХОРОО | ГАЗРЫН БАЙРШИЛ | ЗОРИУЛАЛТ | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ТӨЛӨВЛӨЛТИЙН НЭГЖ ТАЛБАР | ХУГАЦАА | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
| 1. | 13 дугаар хороо | Шувуун фабрик | Нийтийн эдэлбэр | 2.40 | 4287017 | I-IV улиралд | НГЗБА, НХБХСГ, ДЗДТГ |
| | Нийт | | | 2.40 | | | |

| 2.5 Газрын элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Д/Д | ХОРОО | ГАЗРЫН БАЙРШИЛ | ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ХИЙГДЭХ АЖИЛ | ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
| 1. | 12 дугаар хороо | Биокомбинат орчимд | Эвдэрсэн газар | 8 | Хөрсний бохирдол, доройтлыг бууруулах, саармагжуулах ажлыг хийсэн талбайд үргэлжлүүлэн биологийн нөхөн сэргээлт хийнэ. | I-IV улирал | НБОГ |
| 2. | 13 дугаар хороо | Карьер хэсэг | Усан сан бүхий газар | 20.0 | Ногоон зурвас байгуулах | I-IV улирал | НБОГ |
| 3. | 14 дүгээр хороо | Гавьжийн шанд | Усан сан бүхий газар | 0.2 | Хүний болон мал амьтны Булаг шандны эхийг хашиж хамгаалах | I-IV улирал | НБОГ |
| 4. | 14 дүгээр хороо | Түргэн гол дагуу | Усан сан бүхий газар | - | Хөв байгуулах ажлын зураг төсөв хийлгэх | I-IV улирал | НБОГ |
| Нийт | | | | 28.2 | | | |

## ГУРАВ. НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

| 3.1 Инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Д/Д | ХОРОО | ГАЗРЫН БАЙРШИЛ | ЧӨЛӨӨЛӨХ НЭГЖ ТАЛБАР ТОО | ЧӨЛӨӨЛӨХ ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/ | ЗОРИУЛАЛТ | ТӨЛӨВЛӨЛТИЙН НЭГЖ ТАЛБАР | ХУГАЦАА | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
| 3.1.а. Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх | | | | | | | | |
| 1. | 8 дугаар хороо | Жаргалантын ам | 18 | 1.48 | Үерийн хамгаалалтын суваг | 4299643-4299645 | I-IV улирал | ХБХСГ, УБТЦС ТӨХК |
| 2. | 20 дугаар хороо | АШХ-31 дугаар байр | - | - | Дэд станц | - | I-IV улирал | ХБХСГ, УБТЦС ТӨХК |
| 3.1.б. Дулаан хангамжийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх | | | | | | | | |
| 3. | 8 дугаар хороо | Жаргалантын ам | - | 3.8 | Дулааны эх үүсвэр | | I-IV улирал | ЭХЯ, НЗДТГ, ХБХСГ, УБДС |
| 4. | 8 дугаар хороо | Мөсөн гулгуурын зүүн урд талд | - | - | Дулааны шугам | | I-IV улирал | ЭХЯ, НЗДТГ, ХБХСГ, УБДС |
| 5. | 11 дүгээр хороо | Зайсан Хөдөө Аж ахуйн Их сургуулийн Агропаркийн хашаанд | 3 | 1.8 | Хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэр | | I-IV улирал | ЭХЯ,НЗДТГ, ХБХСГ, УБДС |
| 6. | 11 дүгээр хороо | Зайсан орчимд | 6 | 0.07 | Магистраль шугам | 4299641 | I-IV улирал | ЭХЯ, НЗДТГ, ХБХСГ, УБДС |
| 7. | 20 дугаар хороо | Нисэх орчимд | - | — | Магистраль шугам | - | I-IV улирал | ЭХЯ, НЗДТГ, ХБХСГ, УБДС |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | 21 дүгээр хороо | Хорооны нутаг дэвсгэрт | - | - | Дулааны эх үүсвэр | | I-IV улиралд | ЭХЯ, НЗДТГ, ХБХСГ, УБДС |
| *3.1.в. Усан хангамжийн барилга байгууламжийн газрыг чөлөөлөх* | | | | | | | | |
| 9. | 4 дүгээр хороо | Хүүшийн ам орчим | - | - | Тохируулах усан сан | | I-IV улиралд | БОУАӨЯ , УСУГ |
| 10. | 8 дугаар хороо | Буянт-Ухаа-2 хороолол орчимд | - | - | Тохируулах усан сан | | I-IV улиралд | БОУАӨЯ, ХЗЯ |
| **Нийт** | | | **27** | **7.15** | | | | |

| *3.2 Авто зам, замын байгууламжийн газрыг чөлөөлөх* | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **ХОРОО** | **ГАЗРЫН БАЙРШИЛ** | **ЧӨЛӨӨЛӨХ НЭГЖ ТАЛБАР** | **ЧӨЛӨӨЛӨХ, ГАЗРЫН ХЭМЖЭЭ /ГА/** | **ЗОРИУЛАЛТ** | **ТӨЛӨВЛӨЛТИЙН НЭГЖ ТАЛБАР** | **ХУГАЦАА** | **ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА** |
| 1. | 8 дугаар хороо | 640 хүүхдийн суудалтай сургуулийн хойд талаар гэр хорооллын дундах авто зам | - | 650м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 2. | 8, 21, 25 дугаар хороо | Нисэхийн уулзвар | - | | Олон түвшинт уулзвар | | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 3. | 13 дугаар хороо | 7 дугаар хэсэг | | 1391м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 4. | 16 дугаар хороо | Буянт ухаа 2 дугаар гудамж | - | - | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 5. | 16 дугаар хороо | Гэр хороолол дундах авто зам | | 278м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 6. | 16 дугаар хороо | Буянт-Ухаа 6 дугаар гудамж | | 896м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 7. | 25 дугаар хороо | Тайнь-0 гудамжнаас 16-р хорооны 250 дугаар байр хүртэл | | 780м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| 8. | 25 дугаар хороо | Тайнь-1 гудамж | | 1000м | Авто зам | - | I-IV улиралд | ХУДЗДТГ |
| **Нийт** | | | - | **4995м** | | | | |

## ДӨРӨВ. ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

*4. Газрын төлбөрийн орлого бүрдүүлэх чиглэлээр*

| д/д | ЗОРИУЛАЛТ /НЭГЖ ТАЛБАР БҮРИЙГ ЗОРИУЛАЛТААР НЬ АНГИЛНА/ | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /м2/ | ГАЗРЫН ХЭМЖЭЭ /га/ | 1М² ГАЗАРТ НОГДУУЛАХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /ТӨГ/ | ТАТВАР ТООЦОХ ХУГАЦАА | НИЙТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /МЯН.ТӨГ/ | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гэр бүлийн хамтын хэрэгцээ | 10616529 | 1061.65 | 144 | Жилдээ | 1523785.9 | НТГ, ДТХ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА, БХУДЦГХЗ |
| 2 | Төсөвт байгууллага | 679633 | 67.96 | 30 | | 20293.7 | |
| 3 | Нийтийн зориулалттай орон сууц | 1580698 | 158.07 | 70 | | 109984.1 | |
| 4 | Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ | 1571570 | 157.16 | 195 | | 306803.4 | |
| 5 | Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц | 5196 | 0.52 | 1411 | | 7329.7 | |
| 6 | Бүх төрлийн авто зогсоол /газар дээрх, доорх/ | 60641 | 6.06 | 81 | | 4901.8 | |
| 7 | Нийтийн эдэлбэрийн газар | 3576 | 0.36 | 62 | | 221.7 | |
| 8 | Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж | 1267 | 0.13 | 95 | | 120.4 | |
| 9 | Шашин, сүм, хийд | 13621 | 1.36 | 176 | | 2393.2 | |
| 10 | Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/ | 613639 | 61.36 | 314 | | 192871.1 | |
| 11 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл | 8388736 | 838.88 | 13 | | 110025.3 | |
| 12 | Уурхайн эдэлбэрийн газар | - | - | - | | - | |
| 13 | Хөдөө аж ахуйн газар /Тариалан, хадлан, бэлчээр/ | 2675217 | 267.52 | 22 | | 57850.9 | |
| 14 | Тусгай хамгаалалттай газар нутаг /аялал жуулчлал, зуслан/ | 14362822 | 1436.28 | 1279 | | 18363616.3 | |
| | Нийт | 40573145 | 4057.31 | | | 20700197.5 | |